

05.3. Урлагийн тоглолтын үйл ажиллагаа эрхлэгч этгээдийг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур, үзүүлэлт

Үүсэж болзошгүй эрсдэлийн тодорхойлолт: Урлаг, уран бүтээлийн чанар, аюулгүй байдал, хүртээмж алдагдах

Үнэлгээ хийх объект: Театр, чуулга, филармони, соёлын төв, соёлын ордон

№	Шалгуур	Үзүүлэлт
Нэг. Барилга, байгууламж		
1.1	Барилга, байгууламж нь батлагдсан зураг төслийн дагуу баригдаагүй, зориулалтын бус, ашиглалтын болон стандартын шаардлага хангахгүй, сүм, хийдийн сэргээн засварлалт хийгдээгүй	10
1.2	Барилга, байгууламж нь батлагдсан зураг төслийн дагуу баригдсан боловч их засвар хийх шаардлагатай, зарим сүм, хийдийн сэргээн засварлалт хийгдээгүй	5
1.3	Барилга, байгууламж нь эрх бүхий байгууллагаас баталсан барилгын зураг төслийн дагуу баригдсан, зориулалтын, стандартын шаардлага хангасан, сүм, хийдийн сэргээн засварлалт хийгдсэн	1
Хоёр. Техник, тоног төхөөрөмж		
2.1	Техник, тоног төхөөрөмж нь стандартын шаардлага хангаагүй, техник, тоног төхөөрөмжийг зориулалтын бусаар ашигладаг	10
2.2	Техник, тоног төхөөрөмж нь стандартын шаардлага хангасан боловч шинэчлэх шаардлагатай	5
2.3	Стандартын шаардлага хангасан техник, тоног төхөөрөмжтэй, зориулалтаар нь бүрэн ашигладаг	1
Гурав. Хөгжмийн зэмсэг		
3.1	Хөгжмийн зэмсэг нь стандартын шаардлага хангаагүй, эдэлгээний хугацаа дууссан, хөгжмийн зэмсгийг зориулалтын бусаар ашигладаг	10
3.2	Хөгжмийн зэмсэг нь стандартын шаардлага хангасан боловч шинэчлэх шаардлагатай	5
3.2	Стандартын шаардлага хангасан хөгжмийн зэмсэгтэй, зориулалтаар нь бүрэн ашигладаг	1
Дөрөв. Мэргэжлийн боловсон хүчин		
4.1	80 хүртэл хувь нь мэргэжлийн ажилтантай	10
4.2	81-99 хүртэлх хувь нь мэргэжлийн ажилтантай	5
4.3	Мэргэжлийн ажилтнаар бүрэн хангагдсан	1
Тав. Мэргэжлийн урлагийн байгууллагын урын сангийн баяжилт		
5.1	Жилд шинээр болон сэргээн тавьсан 1 уран бүтээлээр урын санг баяжуулсан, эсхүл огт баяжуулаагүй	10
5.2	Жилд шинээр болон сэргээн тавьсан 3 хүртэл уран бүтээлээр урын санг баяжуулсан	5
5.3	Жилд шинээр болон сэргээн тавьсан 4-өөс дээш уран бүтээлээр урын санг баяжуулсан	1

Зургаа. Сан хөмрөг дэх баримтат өвийн хадгалалт, хамгаалалт		
6.1	Нот, партитур, цомнол, зохиолын эх хувь, гар бичмэл, гэрэл зураг, аудио, видео, дүрс бичлэгийн бүртгэл, мэдээллийн сангийн ашиглалт, түгээлт, цахимжуулалт, программ хангамж, хадгалалт, хамгаалалт хангалтгүй	10
6.2	Нот, партитур, цомнол, зохиолын эх хувь, гар бичмэл, гэрэл зураг, аудио, видео, дүрс бичлэгийн бүртгэл, мэдээллийн сангийн ашиглалт, түгээлт сайн боловч цахимжуулалт, программ хангамж, хадгалалт, хамгаалалт хангалтгүй	5
6.3	Нот, партитур, цомнол, зохиолын эх хувь, гар бичмэл, гэрэл зураг, аудио, видео, дүрс бичлэгийн бүртгэл, мэдээллийн сангийн ашиглалт, түгээлт, цахимжуулалт, программ хангамж, хадгалалт, хамгаалалт сайн	1
Долоо. Бүтээлч үйлдвэрлэл		
7.1	Тухайн жилд байгууллагын тайзнаа 4 буюу түүнээс доош соёл, урлагийн олон талт арга хэмжээ зохион байгуулсан	10
7.2	Тухайн жилд өөр тайзнаа 2-оос дээш соёл, урлагийн олон талт арга хэмжээ зохион байгуулсан	5
7.3	Тухайн жилд гадаад улсад болон үндэсний хэмжээнд 4-өөс дээш соёл, урлагийн олон талт арга хэмжээ зохион байгуулсан	1
Найм. Тэгш хүртээмж		
8.1	Хүүхэд залууст болон тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан урлагийн боловсрол олгох үйл ажиллагаа явуулдаггүй	10
8.2	Хүүхэд, залууст болон тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан урлагийн боловсрол олгох үйл ажиллагаа тогтмолжоогүй	5
8.3	Хүүхэд, залууст болон тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан урлагийн боловсрол олгох үйл ажиллагаа тогтмолжсон, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулж барилга, байгууламжийн дэд бүтцийг хөгжүүлсэн	1
Ес. Үйлчилгээний соёл		
9.1	Ажилтны үйлчилгээ, харилцаа, хандлага, ёс зүйн асуудлаар сүүлийн 2 жилд 2 буюу түүнээс дээш гомдол гарч байсан	10
9.2	Ажилтны үйлчилгээ, харилцаа, хандлага, ёс зүйн асуудлаар сүүлийн 2 жилд гомдол гарч байсан	5
9.3	Ажилтны үйлчилгээ, харилцаа, хандлага, ёс зүйн асуудлаар гомдол гарч байгаагүй, үйлчилгээний ажилтнууд соёл, ёс зүйн сургалтад хамрагдаж мэргэшсэн	1
Арав. Соёлын төсөв бүрдүүлэлт		
10.1	Төсвийн жилд өр, авлага үүссэн, төсвийн сахилга бат хангалтгүй	10
10.2	Тухайн жилийн батлагдсан төсвийн багцын дүнд багтаан үйл ажиллагаа эрхэлсэн	5
10.3	Тухайн жилийн батлагдсан төсвийн багцын дүнг 50 хувиас дээш нэмэгдүүлсэн, төсөл хөтөлбөр хэрэгжүүлдэг	1
Арван нэг. Дотоодын хяналтын тогтолцоо		
11.1	Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт тавих ажилтангүй	10
11.2	Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт тавих ажилтантай боловч үйл ажиллагаа хэвшээгүй	5

11.3	Байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт тавих ажилтантай, үйл ажиллагаа хэвшсэн	1
Арван хоёр. Өмнөх хяналт шалгалтын түүх		
12.1	Өмнө хийсэн шалгалтаар хууль тогтоомж, стандартын шаардлагыг давтан зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авдаггүй	10
12.2	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг зөрчсөн, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг бүрэн хэрэгжүүлдэггүй	5
12.3	Хууль тогтоомж, стандартын шаардлагыг биелүүлж ажилладаг	1

Үнэлгээ:

60-120 оноо авсан бол их эрсдэлтэй

36-59 оноо авсан бол дунд эрсдэлтэй

35 буюу түүнээс доош оноо авсан бол бага эрсдэлтэй